

**Өлгийсумын ЗДТГ-ын 10-р сарын 26-с эхлэн 7 хоногт хийсэн ажлын
мэдээлэл**

2018-11-01

- 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Өлгий сумын ГХУСАЗСЗ, Өлгий сумын ЗДТГ-ын санаачилгаар “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” сэдвийн хүрээнд Өлгий сумын баг бүрээс 5 хүн нийт 70 иргэн оролцуулсан сургалт зөвлөгөөн зохион байгуулав.
- Тус сургалтанд Аймгийн шүүх, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Муфтият холбоо, Пазилет энэрэл ТББ эдгээр байгууллагууд “Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийн талаар”, “Гэр бүлийн хүчирхийлэл, шүүн таслах үйл ажиллагаа, өнөөгийн байдал”, “Архины хор хөнөөл”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд шашны үр нөлөө”, “Гэр бүлийн хүчирхийллээс хүүхдийн эрх зөрчигдөх нь” сэдвүүдийн хүрээнд тус тус илтгэл мэдээлэл тавьж хамтарч ажиллав.
- БЗДарга нар Угарын хийгээс урьдчилан сэргийлэх талаар ард иргэдэд сурталчилгаа хийж бичиг тарааж ажиллаж байна.
- Жол ХХК-ны захирал Б.Көксегенд 3 дугаар цэцэрлэгийн урьд тавигдсан шороон замд хурд сааруулагч тавих талаар бичиг хүргүүлэв.
- Багийн нийгмийн ажилтан нар багийн айл өрхүүдээр явж судалгаа авч ажиллаж байгаа.
- Өлгий сумын сургууль цэцэрлэгүүдийн өвөлжилтийн бэлтгэл ажлын тайлангаа нэгтгэж гаргав.
- Нохой устгах ажлыг эрчимжүүлж, үргэлжлүүлэн хуваарийн дагуу багуудаар явж нохой буудаж устгал оруулж байна .
- Хотын гудамжны гэрэлтүүлгийн эвдэрсэн хэсгийг янзалж засвар хийж байна.
- Хогийн толгойн хогийг түрж тэгшлэн хог асгах нөхцөлөөр хангаж өдөр болгон жижиг ковшоор ажиллаж байна.
- Худалдаа Үйлчилгээний цэг салбаруудаас хог хаягдлын хураамж, төлбөр авах талаар БОХУБайцаагч, байгаль хамгаалах идэвхтэн хамгаалагч нартай хамтран ажиллаж, энэ 7 хоногт 150,0 төгрөгийн орлогыг тусгай татварын дансанд оруулсан болно.
- Худалдаа Үйлчилгээний цэг салбаруудын өнгө үзэмжийг сайжруулах талаар албан шаардлага хүргүүлж ажиллаж байна.
- Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгож, нийт 700.0 төгрөгийг татварын дансанд оруулсан.
- Өнгөрсөн 7 хоногт сумын ИТХ-аас гарсан 40 тоот тогтоолын дагуу Сумын Засаг даргаар байгуулсан ажлын удирдамжаар Төвийн зарим ААНэгж, цех салбаруудын хогийн хураамжийн төлбөрт 300.000 мянган төгрөг хурааж төрийн санд төвлөрүүлж үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна.
- Аймгийн МХГазрын байцаагч нартай хамтарч хуучин хайргын карьерд нөхөн сэргээлт хийлгэх талаар газар дээр нь шийдвэр гаргалаа.

Өлгий сумын ЗДТГ